



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 08 сарын 01 өдөр

Дугаар А/545

Мандалговь

Г Төсөл, хөтөлбөр арга хэмжээний санал батлах тухай Г

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, 58 дугаар зүйлийн 58.2.1 дэх заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 12 сарын 04-ны өдрийн 25 дүгээр тогтоол, Аймгийн Засаг даргын зөвлөлийн 2018 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн 12 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 12 сарын 04-ны өдрийн 25 дүгээр тогтоолоор батлагдсан "Хөтөлбөр арга хэмжээ"-ний зардлаас "ЗҮҮН БҮС-2018" төслийг зохион байгуулахад 9,909,000 (есөн сая есөн зуун есөн мянга) төгрөгийг зарцуулсугай.

Хоёр. Арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Дундговь аймгийн шатрын холбооны тэргүүн (С.Сүхбаатар)-д, Ажлын гүйцэтгэл хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир)-д, ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (А.Ганбат)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488610129